BE ALWAYS CONNECTED WITH YOUR LAWYER

ALISON& KATE PARTNERS

LEGAL NEWSLETTER

2026.10.13 №72 AKP Law Firm

Бид 2026 оны 10 дүгээр сарын 13-ны өдрийг хүртэлх батлагдсан онцлох тогтоол, шийдвэрүүдийг танилцуулж байна. Энэхүү мэдээлэлд эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгэгдэн орсон огноог баримталсан бөгөөд тухайн эрх зүйн актын батлагдсан огноо үүнээс өөр байж болохыг анхаарна уу.

I. ЗАСГИЙН ГАЗАР: ОНЦЛОХ ТОГТООЛ

1.1 Журам, жагсаалт шинэчлэн батлах тухай

- “Олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэглэдэхүүн, биобэлдмэл, вакциныг нэг эх үүсвэрээс худалдан авах журам”-ыг;
- “Гаалийн албан татвараас чөлөөлөх спортын зориулалтын тоног төхөөрөмж, хэрэглэлийн жагсаалт шинэчлэн батлах журам”-ыг;
- “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг тус тус шинэчлэн баталсан байна.

1.2 Элчин сайдын яамны консулын хэлтсийн салбар байгуулах тухай

Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин сайдын яамны Консулын хэлтсийн салбарыг Инчон хотод байгуулахаар болсон.

1.3 Махны нөөц бүрдүүлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Нийслэлийн хүн амын 2027 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан нөөцийн мах нийлүүлэгчийг нээлттэй сонгон шалгаруулж, зээлийн хүүгийн дэмжлэгийг зохион байгуулах; нөөцийн махны чанар, эрүүл ахуй, бүрдүүлэлтэд хяналт тавих; хүүгийн дэмжлэгийн нөхцөл, хэмжээ, хугацаа, хяналт, тайлагналыг тогтоож, ил тод мэдээлэх гэх мэт үйл ажиллагааг зохион байгуулж хянахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбатад даалгасан.

II. САЙДЫН ТУШААЛ:

2.1 Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишгийг шинэчлэн батлах тухай

2026 оны 8-р сарын 31-ний өдөр Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/194, А/268 дугаартай тушаалаар шинэчлэн баталж, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 247 дугаар тушаалаар батлагдсан жишгийг хүчингүй болгосон.

III. ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ:

3.1 Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл

2026 оны 10-р сарын 12-ны өдөр дараах журмуудыг батлав.

- Ховд аймгийн Жаргалант суманд мөрдөгдөх "Шим-Ус" ТБОНӨО ХХК-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, суурь хураамж батлах тухай
- Орхон аймгийн Баян-Өндөр суманд мөрдөгдөх хэрэглэгчийн цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, суурь хураамж батлах тухай
- Нийслэлийн Багануур дүүргийн "Багануур-Ус" ААТҮГ-ын цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, суурь хураамж батлах тухай

Тус журмууд 2026 оны 11-р сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөнө.

ALISON & KATE PARTNERS
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, Centrum Office, 3 давхар, 301/а
Web: www.akp.mn
E-mail: contact@akp.mn
Tel: 7704-1414, 8013-0414